



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Г “Нарантуул шейл ойл корпорейшн” ХХК-д Ү
брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Нарантуул шейл ойл корпорейшн” ХХК -д үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Нарантуул шейл ойл корпорейшн” ХХК /А.Одмаа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН